

## “АВСТРАЛИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР”

### Хөтөлбөрийн товч танилцуулга

Австралийн сургалтын тэтгэлэг нь:

- хувь хүний чадамж, манлайлах ур чадварыг хөгжүүлснээр тухайн улс орны хөгжилд хувь нэмэр оруулах
- хувь хүн, байгууллага, улс орны түвшинд хүмүүс хоорондын харилцаа холбоог хөгжүүлэх зорилготой.

### Шалгуур үзүүлэлт

- **Цахим өргөдөл хүлээн авах хугацаа (Жил бүрийн 2 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 30-ны хооронд)**

Тэтгэлгийн зэрэг, хугацаа	Магистрын зэрэг	1- 2 жил
<b>Шалгуур үзүүлэлт</b>	<p><u>Нийтлэг шалгуур:</u></p> <ol style="list-style-type: none"><li>1. Монгол улсын иргэн байх</li><li>2. Өргөдөл гаргах үедээ сүүлийн 2 жил Монголд ажиллаж, амьдарсан байх</li><li>3. Австралид байнга оршин суух виз хүсч өргөдөл гаргаагүй, эсвэл Австралийн иргэншилтэй бус байх</li><li>4. Австрали эсвэл Шинэ Зеланд улсын иргэнтэй гэрлээгүй эсвэл хамтран амьдраагүй байх</li></ol> <p><u>Монгол Улсаас өргөдөл гаргагчдад зориулсан онцлог шалгуур</u></p> <ol style="list-style-type: none"><li>5. Монгол улсын их дээд сургуульд бакалаврын зэрэг эзэмшсэн бол дипломын голч нь 3.0 буюу түүнээс дээш байх, бусад оронд бакалаврын зэрэг дүүргэсэн бол Австралийн их дээд сургуулиудад хүлээн зөвшөөрөгдөхүйц байх</li><li>6. Улаанбаатар хотоос өргөдөл гаргагчид Academic IELTS ийн голч оноо 5.5 аас доошгүй (эсвэл TOEFL-ийн дүйцэх), нэгж оноо 5.0-аас доошгүй дүн бүхий хүчинтэй гэрчилгээтэй байна</li><li>7. Хөдөө орон нутгаас болон хөгжлийн бэрхшээлтэй өргөдөл гаргагчид Academic IELTS ийн голч оноо 5.5-аас доошгүй (эсвэл TOEFL-ийн дүйцэх), нэгж оноо 5.0-аас доошгүй дүнтэй, хүчинтэй гэрчилгээтэй байна</li><li>8. Өргөдөл гаргах үедээ сүүлийн 2 жилийн турш тасралтгүй ажилласан байх</li><li>9. Төрийн албанаас өргөдөл гаргагчид сүүлийн 2 жил төрийн байгууллага, төрийн өмчит компанид ажилласан байх</li><li>10. Хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ мэдүүлж, нотолсон өргөдөл гаргагчдад хоёр жил тасралтгүй ажил эрхэлсэн байх шаардлага тавигдахгүй</li></ol>	

## Сонгон шалгаруулалт (Магистрын зэрэг)

1



**1-р шат:**  
Тэтгэлгийн шалгуур хангасан эсэх болон шаардлагатай бичиг баримтын үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлсэн эсэхийг шалгана

2



**2-р шат:**  
Австралийн хараат бус зөвлөхүүд өргөдлийн материалыг оноогоор үнэлж, эрэмбэлнэ.

3



**3-р шат:**  
Хураангуй жагсаалтад орсон өргөдөл гаргагчидтай ярилцлага хийнэ. Тухайн жилд олгогдох тэтгэлгийн тоо Австралийн засгийн газраас баталсан төсвийн хэмжээнээс хамаарна



**Шалгаруулалтын эцсийн дүн гарах, тэтгэлэгт хамруулах санал тавих**

**Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол доорх цахим хуудсанд хандана уу:**

- [www.australiaawardsmongolia.org](http://www.australiaawardsmongolia.org)